

эртний үг, эцэг өвгөдийн сургаал захиасыг үндэслэн хойт үеийн үр ач нартаа хагарал бутралгүй эв нэгдэлтэй явахыг захиж сургасан, эртний монголын ард түмний амьд үг хэллэг, бичлэгийн өндөр түвшинд газар дэлхий доргисон түүхэн үе, нийгмийн ээдрээтэй амьдралыг үнэн бодитой, баялаг гүнзгийгээр тусган харуулсан, нүүдэлчин аймгуудыг нэгтгэснийг тод томруун дүрсэлсэн, Монгол үндэстний феодалын үеийн эзэн Чингис хааны баатарлаг дүрийг бүтээснээс гадна, Чингис хааныг хүрээлэн буй 100 гаруй баатрын дүрийг дүрсэлсэн зэргийг дэлгэрэнгүй дурьджээ. Энэ бүтээлийн гол ач холбогдол нь «товчоо»-нд сэргэн мандсан тулгар төрийг бат бэх байлгах гэсэн санаа зорилготойгоос гадна «Нууц товчоо» гэдэг нэрний «Нууц» гэсний учрыг тайлбарлан, тэр үеийн ноёд, язгууртнуудын гарал үүсэл, хаан ширээнд гарах хүртлээ хийж байсан хэрэг явдлууд, тэр үеийн нийгмийн байдлыг үнэн байдлаар дүрсэлсэн тул, нийтэд тараах, гаднын хүнд танилцуулахыг хориглож, ордонд ганцхан хувь хадгалж байсан тул «Нууц товчоо» гэж нэрлэсэн гэдэг санааг батлах, баримт материал бүрдүүлснээрээ «Нууц товчоо»-ны орчин үеийн судлалд ач холбогдолтой юм. Орчин үед «Нууц товчоо»-г судлах талаар БНХАУ-д нэлээд ажил хийж байгаа бөгөөд «Нууц товчоо»-ны талаар судалгаа хийдэг хүмүүсийг дурьдвал: Цай Мэйбяо, Юй Дажүнь, Дорнотив, Оюундалай, Асралт, Баяр, Мансаан, Элдэнтэй, Адшаажав, Чингэлтэй, Булаг Дугаржав нарын зэрэг эрдэмтэн, судлаачид байна.

**«МОНГОЛЫН НУУЦ
ТОВЧОО» ДАХЬ АРДЫН
АМАН ЗОХИОЛЫН
СУДАЛГАА**

— Бодончирын морины сүүл богино байгаагийн шалтгаан

Х. Хасуми

1. Бүлэг

«Монголын нууц товчоо» (Цашид МНТ гэж бичье)-ны 24-р зүйлд дараахь өгүүлэл бий. Энд раквилцын ром үсгээр буулгасныг тэр чигээр авья¹

Boduncar uruq-a ese to' a (q) daju e (n) de atala ya' un ke' eju qol da' aritu qodoli se' ultu oroq-singqula-yi unuju ükü' esü inu üküsgеi a' asu inu asuqai ke' eju onan-müren huru' u yorciju talbiba yorciju baljun ara (1) gürcü tende ebesun nembüle ger kijü tende aba sa' uba

Энд миний хөндөх асуудал бол дээр иш татсан зүйлийн доогуур зурсан хэсэг юм. Энэ талаар Мураками, Ц.Дамдинсүрэн хоёрын оруулгыг дор сийрүүлье.

1. Муракамын орчуулга²

24. Бодончир урагт тоологдохгүй атал энд юу хийж сууна гээд «Гол дайрт годил сүүлт» хар шинхул мориндоо мордож «үхэх юм бол үхье, амьдрах юм бол амьдаръя» гэж Онон голыг уруудан давхиж одов.

Удалгүй Балжийн аралд хүрч, тэндээ өвсөн дээвэртэй гэр хийж амьдран суув.

П. Дамдинсүрэнгийн орчуулга³

Бодончир урагт эс тоологдох атал, энд юу хийж сууна гээд гол дайрт годил сүүлт орог шинхул морио унаж үхвэл үхье, амьдарвал амьдаръя гэж Онон руу зорьж одов. Тэнд Балжийн арал гэдэг газар хүрч өвсөн эмбүүл гэр барьж суув.

(Япон орчуулга) Бодончир «Урагт эс тоологдох атал, энд юу хийж суух вэ» гээд гол дайрт годил сүүлт орог шинхул⁴ морио унаж, үхвэл үхье, амьдарвал амьдаръя» гэж Онон голыг зорьж одов. Тэнд Балжийн арал гэдэг газар хүрч өвсөн овоохой барьж суув.

Дээрх хоёр хүний орчуулгын аль алинд нь бага зэргийн ялгаа байгаа ч гэсэн хоёулаа утгын хувьд гажаагүй зөв гэж бодож байна. Гэвч эхний иш татсан зүйлд миний доогуур нь зурсан хэсэг өөрөөр хэлбэл qol da aritu qodoii se' ultu (нуруу нь авагдсан, оготор сүүлт) гэсэн хэсэгт хоёр орчуулга хоёулаа төдийлөн гүн ороогүй мэт бодогдож байна.

Би энэ хэсэгт санал зөрж байгаа тул түүний агуулга, үүргийн талаар өөрийн бодлоо өгүүлье. Тэгэхээр «МНТ»-ны энэхүү хэсгийг улам зөв ойлгон эцсийн эцэст уг зохиолыг бүхэлд нь тайлбарлах, цаашилбал бүтцийг судлахад дуслын төдий ч нэмэр болбол судлаач над үүнээс илүү баяр баясгалан үгүй болой.

Ингээд би «гол дайрт годил сүүлт»-ийн унаж явсан хүн нь хэн нэг хүн бус, Чингис хааны өвөг, аймшиггүй зоригт, нэр хүндтэй Бодончир учраас энэ үгийн утгыг бодож эхэлсэн юм. Эгэл жирийн цэрэг сэн бол өөр хэрэг, гэвч ийм том баатар унахад яагаад ч тохирохгүй морь биш үү. Энэ бол Япон хүн миний ойлголт юм. Гэвч сайтар бодоод үзвэл монголын эртний сонгодог бүтээлийг япон хүний сэтгэлгээ, логигоор ойлгох бус, харин монгол хүний өөрийн нь сэтгэлгээ, логикт тулгуурлан ойлгох хэрэгтэй нь дамжиггүй буй заа.

Тэгэхээр ардын аман зохиолоос монгол хүний сэтгэлгээ, логик урган гардаг уу гэвэл гардаг. Би ардын аман зохиол гэдгийг дараахь маягаар ойлгож байна. Тухайлбал баатарлаг туульсыг аваад үзье. Одоо ойролцоогоор 300 орчим гэж тооцогддог монголын баатарлаг туульс (үүний дотроос 40-ийг би ашиглаж байна) нь анх одоогийнх шиг хэлбэрийн бүтээл байсан уу, үгүй юу гэдгийг мэдэхгүй. Үүний зэрэгцээ олон түмний ам дамжуулан ярьж ирсэн зүйл үү, эсвэл өөрчлөгдөн хөгжсөөр олон түмний бүтээл болсон уу гэдэгт эргэлзээ бий. Би одоо эдгээрийн алинд ч албан ёсны хариулт өгч чадахгүй. Гэвч ардын аман зохиол, ямар ч байсан олон түмний утга зохиол байсан гэж бодож байна. Үүний шалтгааныг хэлэхэд хялбар юм. Өөр нэгэн газар бичсэнчлэн⁵ нөлөө бүхий талынхан ардын аман зохиолын янз бүрийн төрлийг нүд үзүүрлэн хавчин давшилж байв.

Засгийн эрх барьсан хүн бол өөрийгөө өчүүхэн төдий эсэргүүцсэн хүнтэй эвлэршгүй тэмцэх нь мэдээж. Ингээд тэдний эсрэг байр сууринд байгаа хүмүүс гэдэг нь өөрөөр хэлбэл ардын аман зохиолыг дэмжин туслаж ирсэн олон түмэн бөлгөө. Олон хүнээр дэмжигдэхгүй зүйл бол эрт орой хэзээ нэг цагт устаж үгүй болох тавилантай. Дэмжигдэж байгаа зүйл нь ардын аман зохиолын янз бүрийн төрлийн цөм болж уламжлагдан дамжиж ирэв.

Дашрамд «дэмжигдэх» гэдэг үгийн утгын талаар нэг үг хэлье. Энэ бяцхан өгүүлэлд би энэ үгийг дараахь утгаар хэрэглэсэн юм. Нэг үгээр хэлбэл ардын аман зохиолын дотор бичсэн зүйл олон хүмүүст «жинхэнэ» хүлээн зөвшөөрөгдөн өөрөөр хэлбэл «байх ёстой төрх», «сэтгэх байдал»-ын хувьд талархан хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн утгаар юм. Үүнтэй уялдан эдгээр зохиолын дотор дүрсэлсэн гол цөм нь заа-

вал бодит байдалтай яв цав тохирох албагүй. Тухайлбал засгийн тухайд гэвэл тухайн засаг болон ардын аман зохиолын дотор дүрслэгдсэн олон түмэн байх ёстой, эл засаг нь хэлбэрийн хувьд төстэй ч уг чанартаа өөр юм. Чухам иймээс л тухайн засаг нь олон түмэн нэг үгээр хэлбэл ардын аман зохиолын дотор өгүүлж буй өөр засгийг дэмжиж хүлээн зөвшөөрөе гэсэн ард түмэнтэй тэмцэх болдог. Гэвч тухайн засаг хэдийгээр хурц ширүүн тэмцэл явууллаа ч гэсэн түүнийг дэмжих олон түмэн байсан тул ардын аман зохиол нь устаж үгүй бололгүй хэвээр үлдсэн⁶. Ийм учраас ч ардын аман зохиол нь олон түмний зохиол болсон. Ингээд ардын аман зохиолыг чухам хэн зохиосныг мэдэхгүй ч гэсэн урт удаан хугацааны туршид бий болсон ард түмний үнэт шүүмжлэлийн үр дүн нь өнөө хүртэл дамжиж ирсэн гэж бодож байна. Үүнтэй уялдан ардын аман зохиолын дотроос тэдгээр монгол хүний нийтлэг сэтгэлгээ болон сэтгэхүйн ухааныг онцлон авч үзье. Дараахь бүлэгт бодит жишээн дээр өгүүлсүгэй.

П бүлэг.

Монголын ардын аман зохиолыг сөхөж үзвэл нүдний өмнө нүүдэлчин ард түмний хязгааргүй өргөн уудам ертөнц нээгдэх юм. Ялангуяа баатарлаг туульст гардаг аргамаг хурдан хүлэг унасан баатар эрийн үйл хэргийн талаархи бидний төсөөллөөс хол давж байна. Ингээд монголчууд өөрсдийнхөө баатруудын унасан морийг гайхалтай урнаар шүлэглэн дуулж байна.

Энд дүрслэхдээ, аргамаг хурдан хүлгийн хурд, сайхан төрх, сайн удам, дүүхэлзсэн сайхан толгой гээд л ер нь хэлж болох бүх зүйлийг хамруулжээ.

Энэ бяцхан өгүүлэлдээ морины сайхан төрхийн талаар онцлон дүрслээд, үлдсэн зүйлийг харамсалтай нь хойшлуулъя. Ингээд сайхан төрхийн дотроос сүүлний хэлбэрийг онцгой анхаарч үзье гэж бодож байна. «Аянан алдарт, аялган хонгор» гэдэг баатарлаг туульст:⁷

Туулайн сайхан зоогоо агшисхийгээд

Тууш сайхан сүүлээ дэлдэхийгээд

Усаги-но котоки уцукушии сэ-о сюкантики ни чижимэ,

Массугуна уцукушии шиппо-о питто учи футтэ

гэх агаад тэр морь нь ус мэт урсдаг, могой мэт гулгадаг, салхи мэт хийсдэг, жигүүртэн мэт нисдэг, мянган жилийн зовлонг...даадаг алдарт морь юм. Ийм хурдан хүлэг нь шүрэн сайхан сүүлтэй,⁸ туг сайхан сүүлтэй⁹, эсвэл урт сайхан сүүлтэй гэх мэт бий боловч тэр бүрийг тоочиж барахгүй.

Баатарлаг туульст үүнээс өөрөөр морио магтан дуулах өвөрмөц хэлбэр бол магтаал юм. Мөн морины цол (дууны нэр) ч байдаг бөгөөд тэдгээрийн дотор баатарлаг туульсийн адил баатрын хүлэг морь, хурдан хүлэг зэргийг магтан дуулжээ. Тэдгээр бүх төрлийн олон бүтээлд баатрын унасан хүлэг морь, морины уралдаанд түрүүлсэн хурдан хүлгийн сүүл нь бараг цөм л дээр өгүүлсэнчлэн магтан дуулагддаг билээ. Сүүлийг тууш, шүр сайхан гэж дүрсэлдэг. Үүний нэг адил баатарлаг туульс ба магтаалд муу морины тухай ч бараг хэвш - мэл мэт өгүүлдэг. Тухайлбал:

Уул харах нүдгүй

Лууль хазах шүдгүй

Барьж мордох дэлгүй

Батгана шарвих сүүлгүй¹⁰ гэх мэт үүнээс харахад манай гол баатар Бодончирын хүлэг нь ардын аман зохиол дахь баатар эрсийн сайхан хүлэгтэй өнгөц харахад төстэй ч огтхон ч адилгүй морь гэдгийг ойлгосон болов уу гэж бодож байна.

Харин муу морьтой төстэй бус уу. Гэвч дээр өгүүлсэн баатар эрс, түүний хурдан хүлэг нь үнэндээ хувирах увидастай шидэт морь байдаг. Тэгвэл ардын аман зохиолд гардаг баатар ч, морь ч Бодончир түүний годил сүүлт хүлэг шиг болно. Дараахь бүлэгт хувиран өөрчлөгдөх шидэт зүйлийн тухай өгүүлье. Монголын нэгэн зүйр цэцэн үгийг доор сийрүүлье.

Даахин дороос морь

Дахан дороос эр

Энэ зүйр үгийн «морь, даахь» гэсэн үгийг харангуутаа сайн хүлэг гэсэн ойлголт төрөхгүй бизээ. Гүйлгэн уншсан төдийд ойлгохгүй, нэг үгээр хэлбэл өнгөн талаас харж шүүмжлэхэд бус уг зүйлийн агуулгад гүнзгий нэвтрэн ороход асуудлын цөм оршиж байгаа юм. Ингээд миний энд жишээ болгон авсан нь тохиолдлын зүйл бус харин Монголын баатарлаг туульст дүрслэгдэх баатар шидэт хурдан хүлгийн тухай өгүүлэхийг хүссэн юм. Тэдгээр баатар эрс 100 янзын мянган зүсийн тэс өөр юм» болон хувирна.¹¹ Мөн тэдний хүлэг морьд ч хувиран өөрчлөгддөг. Тэдгээр баатрууд заримдаа шувуу, загас болж хувирна. Гэвч хамгийн чухал хувиралт нь «тэс өөр болон» хувирахаас гадна хувцас солигддогт оршино. Нэг үгээр хэлбэл Монголын баатарлаг туульсын баатар нь голдуу нусгай жур¹² хүү эсвэл нусан жур, сайхан хүлэг нь хамуутай бор даага (2 настай адуу) болон хувирна. Зөвхөн зүс хувиралт төдийгүй хувцас нь ч солигдон хувирах явдал, хувиран өөрчлөгдөхийн өмнө янз бүрийн сайхан үгээр магтагдаж байсан ч тэрхүү ид шид, увдис нь хувирсны дараа л сая бүрэн илрэн хэрэгждэг. Түмэн дайсантай амь наана, там цаана тулалдахдаа ч, морин уралдаанд ч өрөвдөм амьтан болон зүс хувирсны дараа л ялалт байгуулдаг. Энэ нь «баатар эр ч, аргамаг хурдан хүлэг ч гаднах үзэмжээсээ болж шүүмжлэгдэх бус, гаднах төрх нь хэдий өрөвдөм ч дотор нь нууцлагдан хадгалагдаж буй жинхэнэ хүч чадлаас хамаарч үнэлэгдэнэ» гэдэг монгол хүний сэтгэлгээг үүгээр төлөөлүүлэн харуулж байна.

Дашрамд хэлэхэд баатар эр, түүний аргамаг хурдан хүлэг яагаад зөвхөн нусгай жур (хүү), хамуутай бор даага болон хувирч байна вэ? Үүнийг дараахь маягаар тайлбарлъя. Нусгай жур ч, хамуутай бор даага ч хоёулаа бага балчир, хүч чадал сул дорой. Гэвч нэг талаар тэднийг үйл бүтээх бололцоо ирээдүй хүлээж байна. «Бага балчир, сул дорой болон хувирч дайсантай халз тулдаг» нь өөрөөр хэлбэл эсрэг этгээдийн анхаарлыг сарниулах гайхамшигт стратеги болдог. Учир нь хэдий өрөвдөм амьтан болон хувирсан ч гэсэн жинхэнэ хүч чадал, увдис нь урьдын адил өөрчлөгдөөгүй хэвээр байдаг.

Дашрамд өгүүлэхэд энд хамуутай бор дааганы тухай тодорхой тайлбарлах хэрэгтэй болов уу. Я. Цэвэлийн монгол хэлний толь¹³-д хамуу, бор, даага гэсэн 3 үгийг дараахь маягаар тайлбарлажээ.

1. Хамуу: Маш их загатнах, арьсны халдварт өвчин

2. Бор: хар цагаан холилдсон өнгө, зүс

3. Даага: 2 настай адуу

Эдгээр 3 үгийг холбож үзвэл, хамуутай бор даага болох тул энэ үгийг сайтар ойлгуулахын тулд нэмж тайлбарлах нь зохистой болов уу. Дээр өгүүлсэн 3 үг дараахь утгатай болов уу. Тухайлбал: Хамуу гэдэг нь «жижиг гүврүү, хармагц л арьсны өвчин гэж ойлгохоор байдлыг» заах бөгөөд, Бор: гэдэг үгэнд «цайвар биш» гэсэн утга бий. Монголчуудын дийлэнх нь цайвар өнгөнд дуртай тул бор өнгийг тийм ая-

тай өнгө гэж үздэггүйтэй холбож болох юм. Гэвч уг даага өсч бойжих бүр хар, цагаан холилдсон өнгөний аль нэг нь давамгайлан тодорч ирэх» талтай.

Ингээд дааганы талаар дараахь зүйлийг хэлэх хэрэгтэй. Монголд газар нутаг хүмүүсийн аль аль нь өөрийн онцлог ялгаатай байдгаас гадна малын насыг маш нарийн ангилдаг. Зарим материалаас үзэхэд морины насыг 1— 15 нас хүртэл нь 14 хэсэг хувааж¹⁴ байна. Даага бол дээрээсээ 2 дахь нь учир 2 настай адуу гэж орчуулъя. (Дээрх материалд 1 настай адуу гэжээ).

Монголд адууг-дааган үеэс нь эхлэж ашиглах байдлаар нь хэд хэд ангилдаг. Тухайлбал, азарга, уналгын морь, эдэлгээний, хүнсний адуу гэх мэт. Сонгон тусгаарлахдаа үндсэндээ хүч чадлыг харгалздаг. Энэ тохиолдолд азарганаас бусад бүх адуу хүч султай байдаг. Ингээд уналгын морь гэж шилсэн даагыг сургаж байж морь болгоно. Сайн морь болох үгүй нь тухайн үеийн сургалтаас гадна морины удмаас шалтгаална. Сургалтын явцад дааганы муу хөлсийг сайн гаргахад ихээхэн анхаарсан тохиолдолд тарга тэвээрэг сайн авч, унаган үс нь унаж, үсний өнгө засран сайжирч ирэх нь хурдан байдаг гэж зүй ёсоор үздэг.¹⁵

Орчин үеийн шинжлэх ухаан хөгжсөн өнөө үед ч уламжлалаа хадгалан байгаа энэхүү бодит байдалд тулгуурлан дааганы тухай эрэгцүүлж бодох нь хамгийн зүйтэй гэж би бодож байна.

Түүнчлэн даага бол сул дорой учраас морин уралдаанд оролцуулалгүй, зөвхөн ойрын зайнд сойж¹⁶ уналгад хэрэглэхийн зэрэгцээ айл саахалтад очих гэх мэт ойр зуурын юманд хэрэглэнэ. Эдгээр зүйлийг мэдсэний дараа урьд өгүүлсэн бор дааганы тухай дахин өгүүлье. «Адуу дааган үедээ гадаад төрх, дотоод чанар, нэг үгээр хэлбэл жинхэнэ хүч чадал нь үл мэдэгдэнэ. Гэвч бусад насанд бус зөвхөн энэ л үе нь хожим сайхан морь болох замыг тавьж өгдөг. Үүнтэй уялдан сайхан морь хувирахдаа ямар ч өрөвдмөөр байсан хамуутай бор дааганаас өөр юм болж хувирдаггүй гэдэг.

Ингээд баатарлаг туульсын талаар дараахь зүйл бодогдов. Нэг үгээр хэлбэл «хамуутай бор даага бол баатарын «макура котоба» буюу байнгын чимэг үг» ажээ. Цааш нь МНТ-н дахь *dol da' aritu godoli se' ultu* нь ямар морь эсэх, ямар утгаар хэрэглэгдсэн үг болохыг би дараагийн бүлэгт тайлбарлахыг оролдож.

IV бүлэг.

Би үүний урьд бүлэгт баатарын аргамаг хурдан хүлэг яагаад зөвхөн хамуутай бор даага болон хувирсны шалтгааныг өгүүлсэн. Энэ бол мянга, 2 мянгаад жилийн турш адуу маллан амьдарч ирсэн тухайн монгол үндэсний сэтгэхүйн ухааны нэг хэлбэр болон нэвтэрчээ. Нэг үгээр хэлбэл П бүлэгт заасан зүйр үгээр маш тодорхой өгүүлсэн шиг «Ямар нэг юмны чанар, үнэлгээ түүний өнгөнд төдийгүй агуулгад байдаг» гэсэн ойлголт аргамаг хурдан хүлгээс хамуутай бор даага болон хувирах явцад илэрч гарсан.

Монголчуудын энэхүү сэтгэлгээнд тулгуурлан дээрх *qol da' aritti godoli se' ultu* болох морины талаар өгүүлье.

Би П бүлгийг «уул үзэх нүдгүй, лууль хазах шүдгүй, батгана үргээх сүүлгүй» гэдгийг жаахан хөндөө. Энэ морийг уна гэхэд Хувэй Буйдар баатар дүрсхийн уурладгийн шалтгаан бол тэр нь хөгшин азарга¹⁷ байсантай холбоотой. Гэвч ингэсний үр дүнд азарганы цуутай унага авдаг. Энэ баатар хүн унахын аргагүй өрөвдөм азарга унаж байна. Энд Бодончир *qol da' aritu godolse' ultu* морь унасантай

нэлээн төстэй байна. Гэвч энэ нь Бодончирын морийг «өрөвдөм морь гэж үзсэн» тохиолдолд юм. Гэвч жинхэнэдээ Бодончирын морь үнэ хээр «өрөвдөм» байсан уу. Үүнийг нягтлан үзье.

1-рт qol da' aritu нэг үгээр хэлбэр «нуруугаа авахуулсан» гэсэн хэсгийн талаар бодож үзье. Монголын зүйр үгэнд

Сайн моринд эзэн олон

Сайн хүнд нөхөр олон

гэдэг үг бий.¹⁸

Энэ зүйр үгийг уншингуут утгыг нь ойлгоно бизээ. Олон хүн унавал морины нуруу авна гэдэг туйлын зөв. Ингээд бодоход «нуруу авсан морь нь өчүүхэн ч «өрөвдөм» биш, харин ч хэн хүний хүслэн болсон «сайн морь» болох юм биш биз. Сэдвээс бяцхан хазайн өгүүлэхэд монгол хүн бусад хүнд морио зээлж зээлдүүлдэг боловч морины хэрэгсэл, ялангуяа эмээлээ зээлж, зээлдүүлдэггүй бололтой. Монголын орчин үеийн уран зохиолыг уншиж үзэхэд заримдаа, аялан жуулчилж буй хүн бирваазанд сууж нөгөө эрэгт гарахдаа морио үлдээж, зөвхөн эмээл хазаараа авч явах агаад нөгөө эрэгт гарч өөр морь унахдаа өөрийнхөө эмээлийг тохож цаашаа явах явдал ажиглагддаг. За энэ яриаг ингээд орхийё. Ингээд цааш нь юу болоо вэ. Монголд хэвлэгдсэн мал аж ахуйн тухай ном¹⁹ хурдан морины гаднах 6 зүйлийн шинжийг тодруулсан 3-р бүлэгт дараахь зүйлийг өгүүлсэн байна. Үүнд: Дэл сүүл шингэн, үс нь өнгө зүс сайтай, сорлог, эргүүлэг олонтой байдаг гэжээ.

Түүнчлэн саяхан хэвлэгдсэн «Морины шинж» гэдэг номд²⁰ морины шинжийн талаар маш нарийн өгүүлжээ. Үүнийг уншихад сайн морь, алдар цуутай морь гэгдэх морины сүүлний шинжтэй яв цав тохирч байгаа бөгөөд сүүлний уртыг сайн гэж хэлэх нэг хоёр л онцгой тохиолдлоос хэтэрдэггүй байна. Бусад бүх зүйл богиныг онцгойлон эрхэмлэж байдаг. Ганц хоёр жишээ татсанаар хязгаарлъя.²¹ Жишээ нь: 89—90-р тал дахь морины сүүлний 3 онцлог

а) Бүдүүн, оготор ширүүн нь сайн сүүл гэж үзэгдэнэ.

б) Нарийн урт сүүлтэй бол хамгийн муу адуу

в) «Бүдүүн урт» эсвэл «Нарийн, охор, хүчтэй»-г онцлон үзнэ. 2-р жишээ 131-р талд

Үнэгэн 300т адуу бол давхих тутам хурд нь нэмэгдэж, давхилт хүртэл нэн сайхан, тийм сайн морь олж авахад тун хэцүү гэж ярьдаг ...

3-р жишээ: 155-р талд «таван сайн охор» бол бэл, бэрэвхий сүүл, бугалаг, хазлуур²² тав болно» гэж бичжээ. Ингээд бодоод үзвэл Бодончирын морийг «өрөвдөм» морь гэж хэлээд цэг тавьж болохгүй. Гол дайрт, годил сүүлт морь байсан нь үнэндээ сайн морь, цуутай морь гэж ярьдаг. Нэг үгээр хэлбэл Бодончир ах дүү нараасаа мунхаг гэж гадуурхагдсан хэдий ч адуун сүрэг дотроос сайн морь шилж олдог сайн шинжээч байсан байна. Ингээд баатарлаг туульсын баатар хамуутай бор даага унаж алдар гавьяа байгуулдагийн нэг адил Бодончир уг морио унаж их үйл гүйцэтгэж байна. Үүнтэй уялдан энэ «гол дайрт, годил сүүлт морь» бол, «баатар адуучин» ч юм уу «морь шинжээч» ч юмуу тэднийг тодотгосон чимэг үг гэж хэлж болно.

«МНТ»-д годил сүүлт морь унаж «их үйл хийж яваа нь Бодончир, Чингис хаан²³ хоёр л юм.

Төгсгөл

Үхсэн гэж бодож явсан хүн гэнэт гарч ирэхэд япон хүмүүс бид энэ хүнд хөл байна уу үгүй гэдгийг мэдэхийг хүсдэг. Энэ нь дундад зуу-

наас «буг чөтгөр, сүнсэнд хөл байхгүй» гэсэн сүжиг байдагтай холбоотой.

Монгол хүн бол хөл байгаа үгүйг нягталдаггүй. Учир нь монголын чөтгөр хөлтэй. «Буг гарах» гэдгийг монголоор буг босох гэдэг. Энэ нь нэг үгээр хэлбэл хөл байгаагийн гэрч юм. Үүн шиг япон, монгол хүн тэдгээрийн хэл, соёл өөр юм «буг чөтгөр» хэдий эвгүй үг гэсэн ч морины нэг адил монгол хүний амьдралтай нягт холбоотой учраас морины талаар төдийлөн гадарлахгүй хүн тэдний сэтгэлгээ, бодит байдлыг үл харгалзан өөрийн сэтгэлгээтэй адилтгаж болохгүй гэж бодож байна.

Уг бяцхан өгүүлэлдээ монголчуудын морины талаархи ерөнхий мэдлэг, сэтгэлгээ ялангуяа нэртэй шинжээч нарын санаа бодолд тулгуурлан бичихийг оролдлоо. Энэ талаар янз бүрийн санал бодол бий гэж бодож байгаа бөгөөд харин би нэг талын асуудлыг хөндөж тавилаа. Судлаач Та бүхнээс санал бодол зөвлөлгөө өгөхийг хүснэм.

Япон хэлнээс орчуулсан **Н. Бадамханд**

¹ Index to the Secret History of the Mongols, by glori de Rachewiltz. Indiana Univ. Pub. Uralic & Altaic Series, Vol. 121, p. 17. LL. 737--741

² Монгору хиши, Чингису-кан моногатаари, Хэйбоншя Тоёобунко, Шова 45 он. Токио, р. 34

³ Монголын нууц товчоо., Ц. Дамдинсүрэн, Улаанбаатар, 1976, 22-р тал

⁴ Энэ хэсэг доторхи орог бол саарал өнгө шинхул гэдэг үгийн утга тодорхой бус

⁵ Токио гайгодайронсю, дай 25 кэн, 1975. Токио. (Монгору кочёо бунгэй)

⁶ Монгол дахь ардын аман зохиолын олон төрөлд ч орчин үед Японы нэгэн адил радио, телевиз дэлгэрч түүнчлэн бичиг үсэг үл мэдэх явдал устсан зэргээс болж харьцангуй үнэлгээ багасаар байна гэж хэлж болно.

⁷ Studia Folclorica. Tomus XI. Fasc. I, pp. 69-83, 1978. Ulan-Bator.

⁸ Богд ноён Жанрай Хаан: Studia Folclorica. Tom XI. Fasc. I. pp. 107—132, Ulan—Batir, 1978.

⁹ Эзэн Улаан Бодон: Studia Folclorica. Tom. I. Fasc. 7. pp. 92—148. Ulan-Bator. 1960

¹⁰ Гөшөө Чулуун Зүрхт. Хүвэй Буйдар Хүү. р. 28. Studia Folclorica. Tom. 1. Fasc. 7. 1960. Ulan-Bator

¹¹ 7-ртай адил. 79-р тал

¹² Жур гэдэг нь нус татах-ын

¹³ Монгол хэлний товч тайлбар толь. , 1966, Улаанбаатар

¹⁴ Үйлчлэх хөдөлмөр IV—VI анги, 1976, Улаанбаатар, 193-р тал

¹⁵ Монгол орны бэлчээрийн мал маллагааны арга туршлага, 1966, Улаанбаатар, 268-р тал

¹⁶ Р. Галиндив, Эрийн гурван наадам 1977, УБ., 55-р тал

¹⁷ Монголд азарга бараг унадаггүй

¹⁸ Монгол цэцэн үгийн далай, Studia Folclorica. Tom. II—I. p. 68. 1964. Ulan Bator.

¹⁹ 15-тай адил. , 272-р тал

²⁰ Морины шинж. Corpus Scriptorum Mongolorum. Tom. XX Fasc. 15. 1978. Ulan-Bator.

²¹ Уг номд эрт дээр үеэс монголын адуучид ялангуяа морь шинжээчдийн бичиж үлдээсэн олон «морины судар» дотроос II шинжийг сонгон эмхэтгэж хэвлэжээ. Үүнтэй уялдан агуулга нь тэдгээр олон шинжээчдийн өнө удаан жилийн ажиглалтын бодит үр дүн гэж бодож байна. Уг материалд «тийм морины тухай» гэж онцлолгүй хурдан хүлгийн талаархи онцгой шинжийг өгүүлсэн.

²² Хазлуур үгийн утга тодорхой бус. Гэхдээ хазах гэсэн үгтэй ойролцоо

²³ МНТ боть 2. 28—32 зүйлд өгүүлнэ.